

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/65/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Өлзийт экаунт аудит” ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/108
танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТЖАРГАЛ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн болон орон нутгийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслэх орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг данснаас хасах, худалдах, шилжүүлэх, акталж устгах, шинээр авах харилцааг аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 7,14 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу барилга, тээврийн хэрэгслийн дуудлага худалдааг нээлттэй зарлан, зохион байгуулж аймгийн төсөвт 255,7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Төв аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 5 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-д заасны дагуу түрээсийн орон сууцанд иргэдийг хамруулсан.

019020238

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлангийн эргэлтийн хөрөнгийн бүлэгт 913,354.9 мянган төгрөгийн түрээсийн орон сууцныг бүртгэн тайлагнасан.

Түрээсийн орон сууцанд иргэдийг хамруулахтай холбогдон авлага, богино хугацаат өр төлбөрийн дансанд барьцаа байршуулсан дүнг бүртгэж 118,124.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,045,272,316.46	1,055,596,310.46
33	АВЛАГА	118,354,888.46	118,943,882.46
335	Бусад авлага	118,354,888.46	118,943,882.46
3352	Хувь хүмүүсээс авах авлага	118,354,888.46	118,943,882.46
35	БАРАА МАТЕРИАЛ	926,917,428.00	936,652,428.00
351	Түүхий эд материал	88,800.00	88,800.00
35130	Эм боох материал	88,800.00	88,800.00
354	Хангамжийн материал	926,828,628.00	936,563,628.00
35410	Бичиг хэргийн материал	742,500.00	1,113,200.00
35420	Аж ахуйн материал	3,678,279.00	3,901,379.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,160,000.00	5,809,000.00
35440	Түлш шатах тослох материал		1,420,000.00
35450	Барилгын засварын материал	88,900.00	2,321,100.00
35470	Бусад хангамжийн материал	921,158,949.00	921,998,949.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	808,047,987.20	820,822,819.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	808,047,987.20	820,822,819.68
392	Биет хөрөнгө	785,560,320.64	798,454,686.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	777,147,193.00	795,280,713.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,361,699.06)	(68,177,422.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,985,000.00	108,985,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44,001,353.83)	(69,835,109.15)
39205	Машин тоног төхөөрөмж	23,802,129.00	46,949,358.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,750,973.07)	(16,628,210.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,274,303.20	12,897,961.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,534,278.60)	(11,017,603.58)
393	Биет бус хөрөнгө	22,487,666.56	22,368,133.29
39301	Программ хангамж	308,000.00	308,000.00
39302	Хасагдуулаг	(205,333.34)	(266,933.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,385,000.00	22,693,000.00
39304	Хасагдуулаг		(365,933.31)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,853,320,303.66	1,876,419,130.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	119,042,370.47	118,124,380.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	119,042,370.47	118,124,380.35
413	Өглөг	119,042,370.47	118,124,380.35
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	112,418.21	0.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	118,929,952.26	118,124,380.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,734,277,933.19	1,758,294,749.79
51	Засгийн газрын хувь оролцоо	1,734,277,933.19	1,758,294,749.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,735,000.00	20,735,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,665,809,628.99	1,689,826,445.59

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	1,665,809,628.99	1,666,144,103.99
51220	Тайлант үеийн үр дүн		23,682,341.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,733,304.20	47,733,304.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,853,320,303.66	1,876,419,130.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	274,935,235.00	516,391,384.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,861,635.00	25,984,524.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,861,635.00	25,984,524.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,766,635.00	25,984,524.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,766,635.00	25,984,524.00
140020	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	265,073,600.00	490,406,860.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,120,000.00	44,035,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч		35,010,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,120,000.00	9,025,000.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	256,953,600.00	446,370,900.00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	256,953,600.00	446,370,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	288,884,291.84	492,709,042.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,884,291.84	492,709,042.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,514,482.81	458,125,989.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,048,000.00	309,173,286.38
210101	Үндсэн цалин	98,771,945.06	192,779,355.62
210102	Нэмэгдэл	27,026,037.74	92,496,505.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,564,798.40	5,183,759.42
210104	Урамшуулал	4,685,218.80	18,713,665.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,748,400.00	39,025,995.07
210201	Тэтгэврийн даатгал	11,513,300.00	27,190,242.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,308,800.00	3,116,066.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,047,000.00	2,336,324.56
210204	Ажилгүйдлийн даатгал	261,800.00	637,692.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2,617,500.00	5,745,668.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,743,996.91	43,276,964.41
210301	Гэрэл, цахилгаан	5,502,642.41	6,743,427.13
210302	Түлш, халаалт	24,678,539.50	35,496,457.28
210303	Цэвэр, бохир ус	562,815.00	1,037,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,399,340.97	15,948,231.91
210401	Бичиг хэрэг	2,341,820.00	3,939,850.00
210402	Тээвэр, шатахуун	7,950,000.00	8,830,000.00

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,107,520.97	3,178,381.91
2105	Норматив зардал	242,550.00	291,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	242,550.00	291,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,022,220.00
210604	Урсгал засвар		3,022,220.00
2107	Томилолт, зочны зардал	10,195,500.00	13,554,400.00
210702	Дотоод албан томилолт	10,195,500.00	13,554,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,387,718.21	1,616,080.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,951,618.21	1,216,845.00
210803	Даатгалын үйлчилгээ		81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,100.00	111,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	198,000.00	205,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,748,976.22	32,217,611.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,811,375.00	7,281,810.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	313,200.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,624,401.72	24,935,801.52
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	369,809.03	34,583,053.11
	Бусад урсгал шилжүүлэг		1,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,700,000.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох, татаас, санхүүжилт	369,809.03	32,883,053.11
	Төвлөрүүлэх шилжүүлэг	369,809.03	32,883,053.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(13,949,056.84)	23,682,341.60
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,824,600.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,824,600.00)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,773,656.84)	23,682,341.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	265,168,600.00	490,406,860.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	95,000.00	
	Бусад орлого	95,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	265,073,600.00	490,406,860.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,120,000.00	44,035,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч		35,010,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,120,000.00	9,025,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	256,953,600.00	446,370,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	262,825,600.00	490,406,860.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,825,600.00	490,406,860.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,455,790.97	455,823,806.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,988,000.00	309,592,298.59
210101	Үндсэн цалин	98,711,945.46	192,784,129.83
210102	Нэмэгдэл	27,026,037.74	92,558,743.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,564,798.00	5,535,759.42
210104	Урамшуулал	4,685,218.80	18,713,665.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,748,400	39,025,995.07
210201	Тэтгэврийн даатгал	11,513,300.00	26,965,098.55
210202	Тэтгэмжийн даатгал	1,308,800.00	3,172,364.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,047,000.00	2,476,291.58
210204	Ажилгүйдлийн даатгал	261,800.00	582,930.95
210205	Эрүүл мэндийн даатгал	2,617,500.00	5,829,309.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,272,900.00	43,748,061.32
210301	Гэрэл, цахилгаан	5,031,545.50	7,160,294.04
210302	Түлш, халаалт	24,678,539.50	35,496,457.28
210303	Цэвэр, бохир ус	562,815.00	1,091,310.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,855,040.97	16,933,011.91
210401	Бичиг хэрэг	2,848,420.00	3,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,950,000.00	10,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,056,620.97	3,183,011.91
2105	Норматив зардал	269,650.00	1,328,050.00

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	269,650.00	1,328,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,618,980.00
210604	Урсгал засвар		11,618,980.00
2107	Томилолт, зочны зардал	10,195,500.00	13,836,800.00
210702	Дотоод албан томилолт	10,195,500.00	13,836,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,412,300.00	1,924,080.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,679,200.00	1,245,845.00
210803	Даатгалын үйлчилгээ		81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,100.00	82,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	513,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,714,000.00	17,816,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,485,000.00	17,148,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	229,000.00	667,920.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	369,809.03	34,583,053.11
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,700,000.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	369,809.03	32,883,053.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	369,809.03	32,883,053.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,343,000.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,343,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,343,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	2,343,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,343,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	2,343,000.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,683,583,285.83	1,752,051,590.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,683,583,285.83	1,752,051,590.03
Тайлант үеийн үр дүн			(17,773,656.84)	(17,773,656.84)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,665,809,628.99	1,734,277,933.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			334,475.00	334,475.00
Дахин илэрхийлсэн	20,735,000.00	47,733,304.20	1,666,144,103.99	1,734,612,408.19
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			23,682,341.60	23,682,341.60
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,689,826,445.59	1,758,294,749.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	451,249,900.00	441,856,193.89	9,393,706.11	97.9%
УРСГАЛ ЗАРДАЛ	451,249,900.00	441,856,193.89	9,393,706.11	97.9%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,249,900.00	440,156,193.89	9,093,706.11	98.0%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304,925,000.00	303,761,998.59	1,163,001.41	99.6%
Үндсэн цалин	240,924,200.00	192,784,129.83	48,140,070.17	80.0%
Нэмэгдэл	58,060,800.00	86,728,443.90	(28,667,643.90)	149.4%
Унаа хоолны хөнгөлөлт	5,940,000.00	5,535,759.42	404,240.58	93.2%
Урамшуулал		18,713,665.44	(18,713,665.44)	
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	38,444,200.00	37,569,682.07	874,517.93	97.7%
Тэтгэврийн даатгал	26,142,000.00	25,974,805.71	167,194.29	99.4%
Тэтгэмжийн даатгал	3,075,500.00	3,055,859.53	19,640.47	99.4%
ҮОМШӨ-ний даатгал	2,460,500.00	2,383,087.54	77,412.46	96.9%
Ажилгүйдлийн даатгал	615,100.00	559,629.95	55,470.05	91.0%
Эрүүл мэндийн даатгал	6,151,100.00	5,596,299.34	554,800.66	91.0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,830,500.00	43,748,061.32	82,438.68	99.8%
Гэрэл, цахилгаан	7,242,700.00	7,160,294.04	82,405.96	98.9%
Түлш, халаалт	35,496,500.00	35,496,457.28	42.72	100.0%
Цэвэр, бохир ус	1,091,300.00	1,091,310.00	(10.00)	100.0%
Хангамж, бараа материалын зардал	16,934,300.00	16,933,011.91	1,288.09	100.0%
Бичиг хэрэг	3,500,000.00	3,500,000.00		100.0%
Тээвэр, шатахуун	10,250,000.00	10,250,000.00		100.0%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,184,300.00	3,183,011.91	1,288.09	100.0%
Норматив зардал	1,590,000.00	1,328,050.00	261,950.00	83.5%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,590,000.00	1,328,050.00	261,950.00	83.5%
Эд хогшил, урсгал засварын зардал	7,788,200.00	7,313,980.00	474,220.00	93.9%
Урсгал засвар	7,788,200.00	7,313,980.00	474,220.00	93.9%
Томилолт, зочны зардал	14,024,300.00	13,836,800.00	187,500.00	98.7%
Дотоод албан томилолт	14,024,300.00	13,836,800.00	187,500.00	98.7%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,713,400.00	1,924,080.00	2,789,320.00	40.8%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	1,245,845.00	2,254,155.00	35.6%

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	136,700.00		136,700.00	
Даатгалын үйлчилгээ	250,000.00	81,675.00	168,325.00	32.7%
Тээврийн хэрэгслийн татвар	216,700.00	82,860.00	133,840.00	38.2%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00		50,000.00	
Мэдээллийн технологийн зардал	560,000.00	513,700.00	46,300.00	91.7%
Бараа үйлчилгээний бусад зардал	17,000,000.00	13,740,530.00	3,259,470.00	80.8%
Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	13,072,610.00	1,927,390.00	87.2%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	667,920.00	1,332,080.00	33.4%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.0%
Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.0%
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	451,249,900.00	446,370,900.00	4,879,000.00	98.9%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	451,249,900.00	446,370,900.00	4,879,000.00	98.9%
Орон нутгийн төсвөөс	451,249,900.00	446,370,900.00	4,879,000.00	98.9%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00%
АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.0%
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-	100.0%
Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	15,667,613.00
УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	15,667,613.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	15,667,613.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	5,830,300.00
Нэмэгдэл	0.00	5,830,300.00
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	0.00	1,456,313.00
Тэтгэврийн даатгал	0.00	990,292.84
Тэтгэмжийн даатгал	0.00	116,505.04
ҮОМШӨ-ний даатгал	0.00	93,204.04
Ажилгүйдлийн даатгал	0.00	23,301.00
Эрүүл мэндийн даатгал	0.00	233,010.08
Эд хогшил худалдан авах	0.00	4,305,000.00
Урсгал засвар	0.00	4,305,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4,076,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4,076,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	44,035,960.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	44,035,960.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	35,010,960.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	9,025,000.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	0.00	15.00
Удирдах ажилтан	0.00	1.00
Гүйцэтгэх ажилтан	0.00	7.00
Үйлчлэх ажилтан	0.00	7.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зохион байгуулахдаа хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангаж, орон нутгийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, бүрэн бүтэн байдал, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих.
- Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил, тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх, зарчимд тулгуурлан шилэн тендер зохион байгуулах.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 20 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 94.58 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны санхүүгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт хийгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан түрээсийн орон сууцны бүртгэлийг шинэчлэн тусгаж, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,098.8 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	118,354.9	118,943.9	589.0
Бараа материал	926,917.4	936,652.4	9,735.0
Үндсэн хөрөнгө	808,048.0	820,822.8	12,774.8
Нийт хөрөнгө	1,853,320.3	1,876,419.1	23,098.8
Өглөг	119,042.4	118,124.4	(918.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	20,735.0	20,735.0	
Хуримтлагдсан үр дүн	1,665,809.6	1,689,826.4	24,016.8
Дахин үнэлгээний нэмэгдэл	47,733.3	47,733.3	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,853,320.3	1,876,419.1	23,098.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, данс байна.

Түрээсийн орон сууцны түрээсийн орлогыг бүртгэх, бүртгэлийн орчин бүрдээгүй, түрээслэгчийн түрээсийн барьцаа төлбөрийн тооцоог авлага дансанд бүртгэн тайлагнаж байна. Оны эцэст түрээсийн тооцооны авлагын үлдэгдэлтэй оршин суугч байхгүй, харин ажилтан албан хаагчаас авах авлагын үлдэгдэл 589.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,735.0 мянган төгрөгөөр өссөн нь 2023 оны эцэст худалдан авсан бараа материалаас шалтгаалсан.

Тайлант онд 865,71 м.кв талбай бүхий 913,397.9 мянган төгрөгийн үнэ бүхий 27 орон сууц эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 12,774.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгөнөөс шалтгаалсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 402,482.3 мянган төгрөг, нийт зарлагыг 402,482.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 48,767.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 451,249.9 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 451,249.9 мянган төгрөгийг 2 удаа тодотгон 48,767.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, тайлант оны эцэст төсвийн зарцуулаагүй 4,514.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 446,370.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 4,514.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 441,856.2 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	70426- Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх				
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	380,389.3	372,000.2	8,389.1	97.8%
1.2	80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	68,860.6	68,156.0	704.6	99.0%
1.3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,000.0	1,700.0	300.0	85.0%
	Дүн	451,249.9	441,856.2	9,393.7	97.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар цахим тендерийн хураамж болон дуудлага худалдааны дэнчин 44,035.9 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгон 28,368.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 7,286.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 4,305.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,076.0 мянган төгрөг, нийт 15,667.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлагыг зүйл тус бүрээр 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70426-Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	2023.01-01-2023.12.31	Төрийн өмчийн эрхийг шилжүүлэх	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөр 97.9 хувь	451,249.9	441,856.2

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 97.9 хувь буюу 2.1 хувиар дутуу зарцуулж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 105,880.7 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: 103,824.5 мянган төгрөгийн цахилгаан дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг шууд худалдан байгуулахаар, 2,056.2 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 103,824.5 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтөлж, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, түрээсийн орон сууцны авлага, өр төлбөрийг тооцоо нийлэн баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 15 -ны өдрийн 04/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 288,884.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 4,333.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,250.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын орон тоог хэмнэх, хавсран ажиллах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 1,163.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 874.5 мянган төгрөг, ашиглалтын зардалд 82.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 1.3 мянган төгрөг, норматив зардал 261.9 мянган төгрөг, эд хогшил 474.2 мянган төгрөг, бусад зардалд 2,976.8 мянган төгрөгөөр өөр тус тус хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс 155 мэдээллийн хугацаандаа, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй хүлээгдэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж, 1 акт өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/166 албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	182.4	1	182.4	100%
Зөвлөмж	4	1,260.5	4	1,260.5	100%
Нийт дүн	5	1,442.9	5	1,442.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дансанд бүртгэлтэй 9 нэр төрлийн 9,672.5 мянган төгрөгийн ашиглалтад байгаа таазны гэрэл, туслах кроп, кропны тос, бичгийн цаас, босоо самбар, дугуй, ажлын хувцсыг тоолж баталгаажуулсан эсэх, ашиглалтын хугацааг дараагийн аудитаар анхааран авч үзнэ үү.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 136,186.7 мянган төгрөгийн алдаа¹илэрснээс аудитын явцад 136,186.7 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

1. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл дүн 124,741.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь, УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Үр дүнгийн тайланд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон 9,025.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэн тайлагнаагүй байна. Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг, алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Санхүүгийн тайлангаарх бараа материалын эцсийн үлдэгдэл, нярвын тайлангийн үлдэгдлээс 2,420.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 3,478.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 170.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,308.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 1,700.0 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгохдоо 170.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй нь ХАОАТ-ын 7 дугаар зүйлийн 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн суутган тооцоогүй татварыг холбогдох этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Түлш шатахууны тооцоотой холбоотой асуудал.

Илрүүлэлт: Түлш шатахууны тайлан бэлтгэхдээ жолооч нартай спидометрийн заалтаар шатахууны хэмнэлт хэтрэлтийн тооцоо бодоогүй 3,308.0 мянган төгрөг байгаа нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал “Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг” , Зам тээврийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглох” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтөлж, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл дүн зөрүүтэй	1	124,741.7			1	124,741.7	1	124,741.7				
Үр дүнгийн тайланд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон орлогыг бүртгэн тайлагнаагүй байна.	1	9,025.0			1	9,025.0	1	9,025.0				
Санхүүгийн тайлангаарх бараа материалын эцсийн үлдэгдэл, нярвын тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй байна.	1	2,420.0			1	2,420.0	1	2,420.0				
Дүн	3	136,186.7			3	136,186.7	1	136,186.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Татвар суутгаагүй олгосон тэтгэмж	1	170.0	1	170.0									
Түлш шатахууны зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй	1	3,308.0					1	3,308.0					